

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 6.2 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 7.7 хувиар давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.8 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 14.6 хувиар давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлага 6.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.2 тэрбум төгрөгөөр буюу 214.3 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 17.9 тэрбум төгрөгт хүрсэн нь 2009 оны жилийн эцсээс 4.9 тэрбум төгрөгөөр буюу 37.8 хувиар өсчээ.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 10.0 тэрбум төгрөг болж, 2009 оны жилийн эцсээс 2.6 тэрбум төгрөгөөр буюу 35.9 хувиар өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Ургац хураалт: Үр тариа 80 га-д, төмс 58.8 га-д, хүнсний ногоо 27.2 га-д, тэжээлийн ургамал 94.4 га-д тариалалт хийж, үр тариа 40 тн, төмс 437.4 тн, хүнсний ногоо 217.2 тн, тэжээлийн ургамал 14.4 тн-ыг тус тус хураан аваад байна. Өнгөрсөн оны мөн үед үр тариа 60.0 тн, тэжээлийн ургамал 18.5 тн, төмс 366.4 тн, хүнсний ногоо 176.0 тн тус тус хураан авсан. Энэ оны хураан авалт өнгөрсөн оноос үр тариа доогуур, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тус тус дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Байгалийн хадлан 11.4 мян.тн, гар тэжээл 1.6 мян.тн тус тус бэлтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс байгалийн хадлан, гар тэжээл тус тус дээгүүр, гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 23.2 тэрбум төгрөг болсон нь урьд оны мөн үеийнхээс 4.0 тэрбум төгрөг буюу 14.7 хувиар доогуур байна. Цайрын баяжмал 2009 оны эдийн засгийн хямралаас болж борлуулалт буурч, бүтээгдэхүүний тоо хэмжээ өссөн нь энэ оны бүтээгдэхүүний үйлдвэрлэлт буурхад нөлөөлсөн байна. Гэхдээ боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 80 хувиар нэмэгдсэн. Үүнд: хэрэгжиж буй төслийн хүрээнд талх, нарийн боов, блок, замын хавтангийн үйлдвэрлэлт өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт 79.5 тэрбум төгрөгт хүрч, урьд оны мөн үеийнхээс 10.9 сая төгрөгөөр буюу 15.8 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байгаагийн дотор боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 34.2 хувиар өссөн байна. Үүнд урьд онуудад үйлдвэрлэгдээд борлуулалт хийгдээгүй тоосгоны борлуулалт энэ онд хийгдсэн нь боловсруулах аж үйлдвэрийн борлуулалтын орлогыг өсгөж байна. Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт бага хийгдсэн нь энэ сард шүлхийтэй холбоотойгоор цайрын баяжмалын борлуулалт хийгдээгүй байна.

Гол нэр төрлөөс талх, нарийн боов, ул боов, хиа, нүүрс, дулаан, блок, замын хавтан, эсгий үйлдвэрлэлт мөн үеэс 11.1-199.6 хувиар нэмэгдсэн байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 10-р сард 2009 оны жилийн эцсийнхээс 8.9 хувиар өссөн байна. Энэ өсөлтөнд тээвэр үйлчилгээний тарифаас бусад барааны бүлгийн үнэ тариф 1.3-31.3 хувиар өссөн нь нөлөөлжээ. Харин Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр, бусад бараа үйлчилгээний үнэ тариф тогтвортой байна. Өмнөх сарыхаас үнэ тарифын ерөнхий индекс 2.7 хувиар өссөн байна

VI. ЭРҮҮЛ МЭНД: 951 эх амаржиж, 960 хүүхэд амьд төрсөн байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 22 болж урьд оны мөн үеэс 7-оор олон, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 5 болж өнгөрсөн оны мөн үеэс 2-оор олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 458 болж, урьд оны мөн үеэс 263-аар доогуур байгаагийн дотор вируст гепатит, салхинцэцэг, тэмбүү, заг, трихоминиаз зэрэг өвчнүүд буурсан байна.

2009 онд гарч байсан гар хөл амны өвчин энэ онд 9 тохиолдол бүртгэгдсэн байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажил идвэхитэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 1212 болж, урьд оны мөн үеийнхээс 94 хүнээр буурсан байна. Ажилгүйчүүдийн 71.4 хувь нь 16-34 насны залуучууд, 19.4 хувь нь дээд, 3.4 хувь нь тусгай дунд, 35.6 хувь нь бүрэн дунд, 7.8 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна. 2373 хүн шинээр бүртгүүлж, 2051 хүн ажилд орсны дотор 612 нь шинэ ажлын байр байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: 143 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 29-өөр доогуур байна. Гэмт хэргийн улмаас 30 хүн гэмтэж, 33 хүн нас барсан байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 108.8 сая төгрөгийн хохирол учирсны 95.2 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 122 хүн холбогдон сэжиглэгдсэний 15.6 хувь нь согтуугаар, 13.1 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 2253 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 93 хүнээр буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 109 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС